



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.04.22 № 1/416

танай _____-ны № _____-т

「 Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2025 оны аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуульд оролцох Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох

6425020530

бусад байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Ардчилсан нам”-ын Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны нөхөн сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөр (7 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг Баянхонгор аймгийн “Ардчилсан намын хороо”-д

Хувийг Баянхонгор аймгийн “Сонгуулийн хороо”-д

Хавсралт 7 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б.МӨНХБАТ

ХЯНАСАН:
АУДИТЫН МЕНЕЖЕР

М.АЛТАНТУЯА

БОЛОВСРУУЛСАН:
АХЛАХ АУДИТОР

Б.ДОЛЖМАА


АУДИТОР

А.АДИЛЗАЯА

АУДИТОР

Д.ОЮУН-ЭРДЭНЭ

Баянхонгор аймгийн АН-ын хорооны
тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж батлав.
2024 оны 03 дугаар сарын 23-ний өдөр



БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМЫН 2025 ОНЫ АЙМГИЙН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛИЙН “БАЯЛАГ БҮТЭЭГЧ БАЯНХОНГОРЧУУД” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн уриа: “ БҮТЭН МОНГОЛ БҮРЭН АРДЧИЛАЛ”

НЭГ. ЭДИЙН ЗАСАГ, ҮЙЛДВЭРЖИЛТ

Нийгэм, эдийн засгийн хөгжил, өрсөлдөх чадвараараа тэргүүлэх 5 аймгийн нэг болно / Манай аймаг 2022 оны өрсөлдөх чадвараараа 21 аймгаас 17-т эрэмбэлэгдэж, нийт 100 оноо авахаас 49,03 оноо авчээ./

1.1. Дэвшилтэт технологи, мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, “Баянхонгорт үйлдвэрлэсэн шилдэг бүтээгдэхүүн”-үүдийг Улаанбаатар болон бусад хотуудын худалдааны сүлжээнд холбож, борлуулалт, зах зээлд өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

1.2. Ноос, ноолуур угаах, самнах үйлдвэрийг орон нутаг, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймагтаа байгуулж үйл ажиллагааг эхлүүлнэ.

1.3. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, технологийн “Хөдөө аж ахуйн кластер”-ийн үйл ажиллагааг өргөжүүлж, мах, сүү, хүнсний ногооны үйлдвэрлэл, борлуулалтын кластер сүлжээг бий болгоно.

1.4. Арьс, нэхийг уламжлалт болон орчин үеийн дэвшилтэт технологиор боловсруулах жижиг, дунд үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ.

1.5. Ахуйн үйлчилгээ, оёдлын үйлдвэр хөгжүүлэх санаачилгыг бүх талаар дэмжиж. Төрийн байгууллагуудын зөөлөн эдлэлийн хэрэгцээг өөрийн аймгийн бүтээгдхүүнээр хангадаг болно.

1.6. Аймгийн төвийн Мах, Сүүний үйлдвэрүүдийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг нэмэгдүүлж дотоодын хэрэгцээгээ хангахын зэрэгцээ бусад аймаг, хотын зах зээлд нийлүүлнэ.

1.7. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар орон нутгийн ААН, үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

1.8. Орчин үеийн технологид нийцсэн барилгын /дулаалга, хайрга, хөөсөнцөр/ материалын үйлдвэрийг төрийн бодлогоор дэмжинэ.

1.9. Аймгийн брэнд бүхий стратегийн бүтээгдэхүүнтэй болж, орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжинэ.

ХОЁР. БОЛОВСРОЛ, СОЁЛ УРЛАГ

Баянхонгор аймгийн хүний хөгжлийн индексийн үзүүлэлт 2012-2016 онд жил дараалан өсөлттэй байсан бол 2022 оны байдлаар энэ үзүүлэлт 0,693 байгаа нь 2016 оноос бараг өсөөгүй байгаа бөгөөд улсын дунджаас 0,088 пунктээр, зэргэлдээ Архангай аймгийнхаас 0,02 пунктээр тус тус доогуур байна.

2.1. ЕБС-дад “Баянхонгорын иргэн” болгон төлөвшүүлэх үндсэн хөтөлбөр, хүмүүнлэгийн болон байгаль экологийн, амьдрах ухааны боловсрол олгох дэд хөтөлбөрүүд хэрэгжүүлнэ.

2.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн “Шинэ багш”, “Зочин багш” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.3. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарт хөрөнгө оруулалт хийсэн иргэн, ААН, байгууллагыг бодлогоор дэмжинэ.

2.4. Сургуулийн өмнөх болон бага боловсролын сургалтын агуулгад бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэх олон талт сургалтыг нэвтрүүлж, хөгжүүлнэ.

2.5. ХАА-н салбарын мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх чиглэлээр ХААИС-ийн салбар, ХАА-н МСҮТ-үүд хамтран ажиллах, кластер тогтолцоог бүрдүүлнэ.

2.6. Орон нутагт нэн хэрэгцээ шаардлагатай мэргэжлийн чиглэлээр жил бүр 100 хүртэлх тооны залуучуудыг сонгон шалгаруулж, гадаад дотоодын нэр хүндтэй их, дээд сургуулиудын тэтгэлэгт сургалтад хамруулах бодлогыг барьж ажиллана.

2.7. Насан туршийн боловсролын төвийг өргөжүүлж, бүсийн сургуулиудыг түшиглэн нэгж, салбарууд байгуулахыг дэмжиж ажиллана.

2.8. Боловсрол, соёл, урлагийн салбарын гадаад харилцааг хөгжүүлж, 100 хүртэлх багш, уран бүтээлчид, удирдах ажилтнуудыг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалт, танилцах аялалд хамруулахыг дэмжиж ажиллана.

2.9. Урлаг, соёлын салбарт нэн шаардлагатай хөрөнгө оруулалтуудыг жил бүр шийдвэрлэхийн зэрэгцээ биет болон биет бус үнэт өвийг хамгаалах, сурталчлах, залуу үедээ уламжлудлан өвлүүлэхийг бодлогоор дэмжинэ.

2.10. Өв тээгчдийг илрүүлж, дэмжиж, урамшуулах, хөгжүүлэх дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

ГУРАВ.ЭРҮҮЛ МЭНД,СПОРТ

3.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, илэрсэн өвчлөлд орон нутагт нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлнэ.


3.2. Хорт хавдраас сэргийлэх зорилтын хүрээнд хавдрын оношилгоо, эмчилгээний хөнгөвчлөх үйлчилгээ үзүүлэх төвийг аймагтаа байгуулж ажиллуулна.

3.3. Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийг биелүүлж, эрүүл мэндээ хамгаалсан иргэдийг урамшуулах тогтолцоог бодлогоор дэмжинэ.

3.4. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн гүйцэтгэлийн санхүүжилтийг сайжруулж, өдрийн болон гэрийн эмчилгээ, асаргаа сувилгаа, сэргээн засах, хөнгөвчлөх үйлчилгээний төрлүүдийг хөгжүүлнэ.

3.5. Эрүүл мэндийн салбарын ажилтнуудын мэргэжил, боловсролыг тасралтгүй дээшлүүлэх, резидент сургалтад хамруулах, ур чадварыг үнэлэх, цалин хангамжийг нэмэгдүүлэх, салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.6. Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр /олон зүслэгт КТГ, MRI, лабораторийн тоног төхөөрөмж/ эн тэргүүнд хангахын зэрэгцээ өвчтөний оношилгооны баталгаажуулалтыг аймгийн эмнэлэгтээ бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ.



3.7. Эмийн сангуудын менежментийг боловсронгуй болгож, чөлөөт өрсөлдөөнийг дэмжин, эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, ханган нийлүүлэлтийг сайжруулна.

3.8. “Шинэ зууны эмч” хөтөлбөрийг хэрэгжүүлж, нарийн мэргэжлийн эмч, эмнэлгийн ажилтнуудыг анагаахын өндөр хөгжилтэй орнуудад мэргэжил дээшлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

3.9. Эрүүл хүнс, эрүүл хооллолтыг бодлогоор дэмжиж, иргэдээ эрүүл хүнсээр хангах асуудлыг үе шаттай төлөвлөж хэрэгжүүлнэ.

3.10. Төв суурины ундны усны эх үүсвэрт шүүлтүүр тавьж, хүн амыг эрүүл ахуй, стандартын шаардлагад ундны усаар хангана.

3.11. Эрүүл мэндийн боловсрол олгох дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлнэ.

3.12. Эмнэлгийн үйлчилгээний очер дараалал, чирэгдлийг арилгаж, хөнгөн шуурхай үйлчилгээг бий болгоно.

3.13. Эмийн бус, нөхөн сэргээх эмчилгээний төв байгуулахыг дэмжиж ажиллана.

3.14. Нарийн мэргэжлийн иж бүрэн тоноглогдсон явуулын үзлэг оношилгооны үйлчилгээг нэвтрүүлнэ.

3.15. Нийтийн биеийн тамир, спортыг олны хүртээл болгож, энэ чиглэлээр санаачилга, амжилт гаргасан иргэн, гэр бүл, сум, баг, байгууллага хамт олныг бүх талаар дэмжинэ.

3.16. Спорт заалуудыг спортын төрлүүдээр төрөлжүүлсэн сургалттай болгоно.

ДӨРӨВ.ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

4.1. Хувийн хэвшлийн хөдөлмөрийн бирж байгуулж, мэдээллийн сан бий болгон, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийг зохицуулах бөгөөд ажиллагсдын хөдөлмөрийн үнэлэмжийг ур чадвартай нь уялдуулан нэмэгдүүлнэ./Хөдөлмөр зуучлалын төв/

4.2. Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

4.3. Иргэдээ ажилтай, орлоготой, өрхийг өсөлттэй болгох замаар ажилгүйдлийн түвшнийг 6,7 хувьд, ядуурлын хамрах хүрээг нэг оронтой тоонд хүргэж бууруулна.

/2022 оны байдлаар манай аймгийн ажилгүйдлийн түвшин 12,7 хувьтай гарч өмнөх жилүүдийнхээс өссөн байгаа бөгөөд, улсын дунджаас 6 хувиар их байна/

4.4.Цагаар ажиллах, гэрээр ажиллах, цахимаар ажиллуулах, сүлжээний маркетинг бүхий бараа, үйлчилгээний борлуулалт хийх зэрэг хөдөлмөр эрхлэлтийн олон хэлбэрийг дэмжих замаар эмэгтэйчүүд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

4.5. Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлж, Орон нутагт ажиллаж буй залуучуудыг дэмжих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

4.6.Залуучуудын хөгжлийн “Community center” байгуулж, чөлөөт цагаа өнгөрөөх, хамтдаа хөгжих, суралцах орчныг бүрдүүлнэ

4.7. Хүүхэд харах үйлчилгээг хөгжүүлэх, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

4.8.Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар өөрийн аймагт дутагдалтай мэргэжилтнүүдийг бүрдүүлэх "Ахмад мэргэжилтний алба" ажиллуулах санаачилга, хөдөлгөөн өрнүүлнэ.

4.9. Өрхийн үйлдвэрлэлийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

4.10. Аймаг орон нутагт Шинэ ажлын байр бий болгосон ААН-үүдийг орон нутгаас урамшуулдаг тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлнэ.

ТАВ. НИЙГМИЙН ХАМГААЛАЛ

5.1.Аймгийнхаа хүн амын эрүүл амьдрах, урт удаан наслах нөхцөлийг бүх талаар хангаж, дундаж наслалтыг нэмэгдүүлнэ. /2022 оны статистик мэдээгээр манай аймгийн хүн амын дундаж наслалт 72.05, улсынх 71,5 байна./

5.2. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ, халамжийн үйлчилгээнд хамрагддаг өрх бүрээс нэг хүнийг мэргэжил эзэмшүүлж, ажлын байртай болгож, хөдөлмөр эрхлэлтийг нь дэмжинэ.

5.3.Хүүхдээ асран хамгаалж байгаа 3 хүртэлх насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийн хүүхдээ өсгөсөн жилийн үнэлэмжийг нэмэгдүүлэх бодлого барина.

5.4. Аймгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "хөгжлийн төв"-ийг түшиглэн тэдэнд хөдөлмөр эрхлэх дэд бүтэц, техник, тоног төхөөрөмжийн таатай орчныг бүрдүүлнэ.

5.5.Ахмад настуудыг сэргээн засах эмчилгээ, сувилалд хамруулах арга хэмжээг бодлогоор дэмжинэ .

5.6. Эмч, багш нар болон төрийн албан хаагчдыг орон сууцжуулах бодлогын хүрээнд 100 хүртэл төрийн албан хаагчдад дэмжлэг үзүүлэх бодлого баримтална.

ЗУРГАА. ӨРХИЙН ӨСӨЛТИЙГ ТЭТГЭСЭН ХӨДӨӨ АЖ АХУЙ

Аймгийнхаа ХАА-н салбарт мах, сүү, төмс, хүнсний ногооны чиглэлээр кластер хөгжүүлж, боловсруулалт, үйлдвэрлэл, тээвэр ложистикийн менежментийг хамтад нь шийдвэрлэнэ. Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлэн, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах бодлогыг хэрэгжүүлнэ.

6.1. "Зуданд зутардаггүй хариуцлагатай малчин" хөтөлбөр хэрэгжүүлж малчдыг хот айл, аравт, хорьтын системээр хөдөлмөрөө хорших боломжийг бүрдүүлнэ.

6.2. Малын гаралтай бүх төрлийн түүхий эдийн боловсруулах үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар малчдын амьжиргаа, орлогыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

6.3.Малчдын залгамж халааг бэлтгэх зорилгын хүрээнд "Залуу малчин өрхийг дэмжин урамшуулах аймгийн хөтөлбөр" боловсруулж,хэрэгжүүлнэ.,

6.4. Тал хээрийн болон говийн бүсийн сумдын хонин сүрэгт Баяд, Барга үүлдэр, Баянбулаг омгийг үндсэн сайжруулагчаар ашиглаж, 1 хонин толгойн амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

6.5. Аймгийн төвөөс 50 км-ийн тойрогт /Өлзийт, Баян-Овоо, Эрдэнэцогт/ мах, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй "эрчимжсэн үхрийн аж ахуй"-г хөгжүүлж, үржүүлнэ.

6.6. "Малын эрсдэлийн сан"-г сум бүрд байгуулан малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсаа, бэлчээр, тэжээл, усан хангамжийг сайжруулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

6.7. Аймаг орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжлээр суралцаж байгаа оюутан хүүхэдтэй малчин өрхөд малын тоо толгойн албан татварын хөнгөлөлт үзүүлэх бодлого барина.

6.8. Мах, сүү, шувуу, гахайны эрчимжсэн фермерийн аж ахуй эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжинэ.

6.9. Аймгийн хүн амын төмсний хэрэгцээг өөрийн аймгийн хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр 100 хувь хангах асуудлыг бүрэн шийдвэрлэж, төмс, хүнсний ногооны тариалалт, хураан авалт, хадгалалт, борлуулалтын кластрын сүлжээг бий болгоно.

6.10. Хүлэмжийн аж ахуйг боломжит сумдад хөгжүүлэхийн зэрэгцээ Баянхонгор, Шаргалжуутыг түшиглэн 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалан хөгжүүлнэ.

6.11. Тэжээлийн ургамал тариалах боломжтой бүсүүдэд инженерийн хийцтэй услалтын системүүдийг бий болгож, тариалалтыг нэмэгдүүлэн, МАА-н салбарын өвс тэжээлийн нөөцийг бүрдүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.

ДОЛОО.ТОГТВОРТОЙ БАЙГАЛЬ ОРЧИН

7.1. Гол горхи,булаг шандын эх болон цөлжилт, хөрсний элэгдэлд орсон газруудад мөн Түй, Байдраг, Шаргалжуут, Цагаан туруут зэрэг томоохон голуудын ай савын дагуу мод тариалж аймгийн ойн сангийн хэмжээг нэмэгдүүлнэ.

7.2.Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх ШУ-ны үндэслэлтэй арга хэмжээг жил бүр хэрэгжүүлэн, бэлчээрийн даацыг сайжруулна.

7.3. Гадаргын усыг хуримтлуулах хөв цөөрөм байгуулж, түүгээрээ усны хэрэгцээг хүртээмжтэй хангах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

7.4.Бэлчээрийн даацад тохирсон МАА-н бодлого хэрэгжүүлнэ.

7.5.Хариуцлагатай уул уурхайн зарчмын дагуу нөхөн сэргээлт, хаалтын асуудлыг тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж бүрэн хариуцан гүйцэтгэдэг болох асуудлыг шийдвэрлэж ажиллана.

7.6.Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд мод үржүүлэх, арчлах ургуулах үйлчилгээ бүхий хувийн хэвшлийн ААН үүдийг дэмжинэ.

7.7. Баялгийн шийдвэрт иргэдийн оролцоог хангах зарчмыг хэрэгжүүлнэ.

7.8. Байгалийн баялгаас орж буй орлого, төсөв, тендерийг иргэдээр хэлэлцүүлдэг тогтолцоог шинэ шатанд гаргана.

7.9.Орон нутгийн эвдэрсэн замыг засварлах,тэмдэгжүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

НАЙМ. ХОТ СУУРИНЫ НОГООН ХӨГЖИЛ

8.1. Байгаль орчинд ээлтэй эко түлш, сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан халаагуурын ашиглалтыг нэмэгдүүлэх, Дулааны цахилгаан станцыг ашиглалтад



оруулах замаар аймгийн төвийн агаар, хөрсний бохирдлыг 50 хүртэл хувь бууруулна.

8.2. Аймаг, сумдын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийг эрчимжүүлж, “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод, хүнсний ногоо тариалж, жишиг гудамжнуудыг бий болгон, төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.

8.3. Иргэд өөрийн өмчилж авсан хашааны газар дээрээ дахин төлөвлөлт хийж, амины орон сууц барих ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хэрэгжүүлж, аймгийн төвийн гэр хорооллын яндан, нүхэн жорлонгийн тоог 20 хувиар бууруулна.

8.4. Аймгийн төвийг тойрсон ойн зурвасыг арчилж, сэргээн хамгаалж ургуулахын зэрэгцээ сум сууринуудыг цэцэрлэгжүүлнэ.

8.5. Баянхонгор хотын цэвэр усны шугамын шаардлагатай хэсгүүдийг шинэчилж, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн стандарт шугамтай болгоно.

8.6. “Тогтвортой орон сууц”, “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аймаг, сумын төвүүдийг орон сууцжуулах бодлогыг Ипотекийн зээлийн бодлоготой уялдуулан хэрэгжүүлнэ.

8.7. Гэр бүлийн хэрэгцээний газраа өмчилж авч чадаагүй, аймаг сумын төвийн өрхүүдэд газрыг нь өмчлүүлэх арга хэмжээг бодлогоор хэрэгжүүлнэ.

8.8. Сум, багийн төвүүдийг шинэчлэх төслийг үргэлжлүүлж, Засгийн газраас хэрэгжүүлэх орон нутгийн автозамын сүлжээнд сумдыг холбох ажлыг эхлүүлнэ.

8.9. Сумдад хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хогийн цэгийг ландшафтын аргаар дарж, хог хаягдлыг дахин боловсруулахыг бодлогоор дэмжинэ.

8.10. Сумын төвүүдийн гэр хорооллыг халаалтын төвлөрсөн шугам сүлжээнд холбох ажлыг үргэлжлүүлнэ.

ЕС. САЙН ЗАСАГЛАЛТАЙ БАЯНХОНГОР

9.1. Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай, ардчилсан, цахим засаглалыг төлөвшүүлнэ.

9.2. Төрийн албан тушаалтантай холбоотой авлига, ашиг сонирхол, ёс зүйн зөрчлийн талаар гаргасан иргэдийн мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, ил тод хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

9.3. Төсвийн зардлыг ач холбогдлоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, үрэлгэн зардлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, аймгийн төсвийн чадавхыг нэмэгдүүлнэ.

9.4. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

9.5. Төрийн албан хаагчдын цалин хөлсийг ажлын байранд өнгөрүүлсэн хугацаагаар бус ажлын үр дүнгээр тооцдог аргачлалыг нэвтрүүлнэ.

9.6. Орон нутгийн өмчит ААН-үүдийн засаглалыг сайжруулж, аль болох нээлттэй, олон нийтийн оролцоотой болгон өөрчилж, тэдний үр өгөөжийг нэмэгдүүлэн, өрийн дарамтыг арилгана.

9.7.Өөрийн аймгийн салбар бүрд шаардагдах боловсон хүчний нөөцийн эрэлт шаардлагад үндэслэн Гадаад дотоодын их, дээд сургуульд гэрээгээр суралцах оюутны тоог үе шаттай нэмэгдүүлнэ.

9.8.Аймаг сумын төсвийн гүйцэтгэлд жил бүр нээлттэй сонсгол, хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэд, олон нийтийн төсөвт тавих хяналтыг сайжруулна.

АРАВ. АЮУЛГҮЙ, АМГАЛАН, АЯ ТУХТАЙ БАЯНХОНГОР

Гэмт хэрэг, зөрчил.

10.1. Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулж, аймаг сумын төвүүдийг телекамерийн хяналтад бүрэн авах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

10.2. Архины хор уршгийг тайлбарлан таниулж, гэгээрүүлэх замаар “Архигүй Баянхонгорчууд” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

10.3. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй аймаг” болохыг зорино.

10.4.Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад анхаарч, хот хооронд, сум хоорондын зорчигч тээврийн замд хяналтын цэг /пост/-уудыг тогтмол хариуцлагатай ажиллуулан, энэ төрлийн гэмт хэрэг, ослын тоог 2 дахин бууруулна.

10.5.Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг шинэ шатанд гаргаж, үр дүнтэй хэрэгжүүлнэ.

Аялал жуулчлал, гадаад харилцаа.

10.6. Аймгийн аялал жуулчлалын мастер төлөвлөгөөг тодотгож хэрэгжүүлнэ.

10.7. Гадаад дотоодын жуулчдад мэдээлэл хүргэх,зуучлах тур операторуудын үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ зорчигч тээврийн ая тухтай аюулгүй үйлчилгээг хөгжүүлнэ.

10.8. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.

10.9.“Баянхонгорын бүтээгдэхүүн борлуулах цэг”-үүдийг ӨМӨЗО-ны Эрээн хот, Эзэнээ хошуудад нээж, тогтмол ажиллуулах.

10.10. Жижиг, дунд болон бичил үйлдвэрлэл эрхлэгчдийг гадаад зах зээлд гарах, хил орчмын худалдаанд идэвхтэй оролцоход нь дэмжлэг үзүүлж, бизнес аялал, хилийн худалдааг зохион байгуулж, малчид үйлдвэрлэл эрхлэгчдийг өргөнөөр оролцуулах бодлого барьж ажиллана.

БАЯНХОНГОР АЙМГИЙН АРДЧИЛСАН НАМ



[Handwritten signatures]